

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ТЭРГҮҮЛЭГЧИД ТҮҮНИЙ АЖЛЫН АЛБАНААС 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД
ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
/2018.01.01 - 2018.06.15-ны байдлаар/**

2018оны 06 дугаар сарын 20

Улаанбаатар хот

**НЭГ. “ХУРЛЫН БАЙГУУЛЛАГЫН БОДЛОГО,
ЗОРИЛТ ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ”**

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын алба хууль тогтоомж, дээд газрын тогтоол, шийдвэр, өөрийн хурал, Тэргүүлэгчдээс дэвшүүлсэн бодлого, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд 2018 онд дүүргийн гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, иргэдийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, өсвөр үе хүүхэд залуучуудын сайн дурын үүсгэл санаачилгыг дэмжих, иргэдийн эрүүл аюулгүй, таатай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хууль тогтоомж, Хурал, Тэргүүлэгчдээс баталсан тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад голлон анхаарч, үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллалаа.

Дэвшүүлсэн зорилтын хүрээнд Хурал, Тэргүүлэгчдээс хэлэлцэх асуудал, Хурлын хороод, Ажлын албанаас зохион байгуулах үйл ажиллагаа, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах, Авлигатай тэмцэх чиглэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тус боловсруулж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнан, үр дүнг тооцон ажиллаж байна.

Тайлант хугацаанд дүүргийн Засаг дарга 17, Хурлын Ажлын алба 16 асуудал нийт 33 асуудлыг Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэхээр өргөн барьсаныг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Хурлын Тэргүүлэгчид Засаг дарга болон Хурлын Ажлын албанаас өргөн барьсан асуудлын хүрээнд нийт 7 удаа хуралдаж, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 14 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээс 14 асуудлыг бүрэн хэлэлцэж, биелэлт 100 хувьтай байна. Цаг үеийн болон бусад асуудлаар 10 асуудлыг хэлэлцэж, нийт 29 /давхардсан тоогоор/ тогтоол, шийдвэрийг баталсан байна. Хурлын Тэргүүлэгчдээс баталсан шийдвэрийг ангилвал:

- Бодлогын баримт бичиг-1
- Дүрэм, журам-2
- Зохион байгуулалтын чиглэлээр-6
- Шагнал, урамшууллын чиглэлээр-12
- Бусад -8

1. Бодлогын баримт бичиг

- Чингэлтэй дүүргийн гадаад харилцааг хөгжүүлэх бодлогын баримт бичиг

2. Дүрэм журам:

- Олон нийтийн хяналтын зөвлөлийн ажиллах журам

- Өсвөрийн сэргийлэгч сайн дурын бүлгэмийн ажиллах журам

3. Зохион байгуулалтын чиглэлээр:

- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2018 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай
- Хурлын Ажлын албаны бүтцэд өөрчлөлт оруулах тухай
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл байгуулах тухай
- Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд иргэдийг оролцуулах тухай
- Аян зарлах тухай
- Зуны түр худалдааны байршил, үйл ажиллагааны чиглэл тогтоох тухай

4. Бусад асуудлын чиглэлээр:

- Өмч шилжүүлэх тухай
- Хөрөнгө данснаас хасах тухай
- Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай
- Буцалтгүй тусламж олгох тухай

Хурлын Тэргүүлэгчид хяналт шалгалтын чиглэлээр дүүргийн Засаг даргын дэргэдэх 2 байгууллагын үйл ажиллагаа, өмч хөрөнгө, хөрөнгө оруулалтын ажилтай холбоотой 2 ажлын явц, гадаад арга хэмжээний 3 удаагийн томилолтын илтгэл, тайланг сонссон байна.

Тайлангийн хугацаанд Хурлын Тэргүүлэгчид хэлэлцсэн асуудлаар 8 заалт бүхий үүрэг чиглэлийг дүүргийн Засаг даргад, 24 заалт бүхий үүрэг, чиглэлийг Хурлын Ажлын албанд, 4 заалт бүхий үүрэг чиглэлийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх хэлтэс, албадад, 6 үүрэг, чиглэлийг тэмдэглэлээр тус тус хүргүүллээ.

Хурлын Тэргүүлэгчдээс баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд 100 хувь буюу бүрэн хэрэгжсэн-15, 0 хувь буюу хэрэгжээгүй 1 ажил байна.

Тайлант хугацаанд Хурлын хороодоос зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан 7 хорооны 26 ажлыг зохион байгуулахаар 5 удаагийн удирдамж, төлөвлөгөө батлагдсан бөгөөд 4 хорооны 21 ажил бүрэн хэрэгжиж, 3 хорооны 5 ажил хойшлогдож, биелэлт 80,7 хувьтай байна.

Хяналт шалгалтын чиглэлээр ажилласан Хурлын хороод дараах байгууллагуудын үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй ажлуудын явц байдал, гүйцэтгэлтэй танилцсан байна. Үүнд:

Эрх зүй, нутгийн удирдлагын хороо:

- “Эрх зүй, нутгийн удирдлагын хороо”-ны нээлттэй өдөрлөг зохион байгуулах

Төсвийн зарцуулалтын хяналтын хороо:

- Чингэлтэй дүүргийн Бизнес инкубатор төвийн үйл ажиллагаатай танилцах /Чингэлтэйд үйлдвэрлэв дэлгүүрүүд, зөөврийн ажлын байр/

- Дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны албаны үйл ажиллагаатай танилцах
- Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудтай танилцах

Хот байгуулалт, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хороо:

- Чингэлтэй дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны албаны үйл ажиллагаатай танилцах
- Чингэлтэйд үйлдвэрлэв- 1, 2 төвүүдийн үйл ажиллагаатай танилцах
- Сервис центр, Сэлбэ дэд төвийн хүрээнд Чингэлтэй дүүрэгт хийгдэх ажилтай танилцах, мэдээлэл авах

Нийгмийн хөгжлийн хороо:

- Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэст байгуулагдсан Түр хамгаалах байрны үйл ажиллагаатай танилцах
- Албан бус насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагаатай танилцах
- Эрүүл мэндийн төвийн Мэс заслын тасгийн үйл ажиллагаатай танилцах
- Дүүргийн харьяа цэцэрлэгүүдийн үйл ажиллагаатай танилцах
- Хүүхэд харах үйлчилгээ, “Багачууд хүнс”-ийн үйл ажиллагаатай танилцах
- Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, цэцэрлэгийн арга зүйч, өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан, хороодын хамтарсан багийн гишүүд, хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн мэргэжилтнүүдтэй “Нийгмийн хөгжлийн хорооны нэрэмжит уулзалт” зохион байгуулах

Хурлын Ажлын алба тайлант хугацаанд төлөвлөгөөнд тусгагдсан нийт 31 ажлаас 30 ажлыг бүрэн хэрэгжүүлж, 1 ажил удирдлагын заалтаар хойшилж, биелэлт 96,7 хувьтай байна.

Хурлын Ажлын албанаас зохион байгуулсан ажлыг ангилбал:

- Дотоод ажлын чиглэлээр-8
- Сургалт, мэдээллийн чиглэлээр-5
- Төвлөрсөн арга хэмжээний чиглэлээр-12
- Гадаад, дотоод арга хэмжээний чиглэлээр-5

Тайлангийн хугацаанд Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын албанд байгууллага, иргэдээс <https://edoc.ub.gov.mn/> цахим сайтаар нийт 131 бичиг тоот, 2 өргөдөл, 4 гомдол ирүүлсэнийг хүлээн авч, хуульд заасан хугацаанд бүрэн шийдвэрлэж ажиллалаа. Мөн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 220 албан бичиг хүргүүлсэн байна.

Ирсэн бичгийг ангилбал:

- Дээд газраас-47

- Дүүргийн ИТХ-ын Төлөөлөгч, Тэргүүлэгчдээс-4
- Дүүргийн Засаг дарга түүний Тамгын газраас-61
- Дүүргийн ЗДТГ-ын дэргэдэх хэлтэс албадаас-11
- Төрийн бус байгууллагаас-6
- Бусад-2

Өргөдөл, гомдлыг ангилвал:

- Төрийн албан хаагчтай холбоотой гомдол -1
- Төрийн үйлчилгээтэй холбоотой гомдол- 2,
- Төлөөлөгчтэй холбоотой гомдол-1
- Тусламж хүссэн өргөдөл-2 байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг Нийслэлийн нэгдсэн өргөдөл, гомдлын сайт www.smartcity.mn цахим сайтад бүртгэн, удирдлагуудад шуурхай танилцуулж, 1 гомдлыг Хурлын Ажлын алба эрхлэх асуудлын хүрээнд бүрэн шийдвэрлэж, 5 өргөдөл, гомдлыг Засаг дарга түүний Тамгын газарт цахимаар шилжүүлснээс 1 гомдлыг дээд шатны байгууллагад шилжүүлж, 2 гомдлын холбогдох арга хэмжээг авч шийдвэрлэн, 2 өргөдлийг дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний бүртгэл судалгаанд тус тус бүртгэн, хариуг хүргүүлж ажилласан байна.

Тайлангийн хугацаанд Хурлын Тэргүүлэгчид Төрийн дээд шагнал, цол, одон, медиалаар шагнуулахаар байгууллага, иргэдээс ирүүлсэн Чингэлтэй дүүргийн харьяат 191 иргэн, “Алдарт эх” 1, 2 дугаар зэргийн одонгоор шагнуулахаар болзол хангасан Чингэлтэй дүүргийн харьяат 347 эхийн тодорхойлолт материалыг тус тус хэлэлцэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжиллаа.

Мөн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнуулахаар ирүүлсэн 219 иргэний тодорхойлолт, материалыг хэлэлцээд дүүргийн хөгжилд хувь нэмэрээ оруулан ажилласан 193 иргэнийг Хурлын дээд шагнал “Чандмань одон”-оор, 26 иргэнийг “Хүндэт өргөмжлөл”-өөр тус тус шагнаж урамшууллаа.

Тайлангийн хугацаанд Хурлын дарга Ажлын албаны үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар 9 захирамж, Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга үндсэн үйл ажиллагаатай холбоотой 58, боловсон хүчинтэй холбоотой 98, нийт 156 тушаал, шийдвэрийг баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2014 оны 01 дүгээр захирамжийн хүрээнд Төсвийн шууд захирагчийн шийдвэрээр нийт 340 зарлагын гүйлгээг анхан шатны баримт бичгийн бүрдэлд үндэслэн хийж гүйцэтгэн, мэдээ, тайланг холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь хүргүүлж, санхүүгийн сар, улирлын мэдээ тайланг нийтэд ил тод байршуулж, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 04 дүгээр тогтоолоор Хурлын Ажлын албаны бүтэц дэх Иргэний оролцоо, олон нийттэй харилцах хэлтсийн албан тушаалыг Төрийн захиргааны ангилал, зэрэглэлд хамааруулсантай холбоотойгоор

тус хэлтсийн нийт 23 албан тушаалын орон тоог Төрийн жинхэнэ албан хаагчдаас бүрдүүлэхээр Төрийн албаны тухай хууль болон Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолын дагуу Нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлд Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын захиалгыг хүргүүлж, 2018 оны 04 сарын 16-24 хүртэлх хугацаанд зохион байгуулж, шалгалтад тэнцсэн 16 иргэнийг Хурлын Ажлын албаны даргын тушаалаар томилж, 7 иргэнийг томилуулахаар Нийслэлийн Төрийн албаны салбар зөвлөлд нэр дэвшүүлсэн. Ангилал, зэрэглэлд өөрчлөлт орсонтой холбоотойгоор тус хэлтсийн албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн боловсруулж батлууллаа.

Хурлын байгууллагын тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх хүрээнд Хурлын Ажлын алба, Хурал дахь намын бүлгийн Ажлын албаны ажилтнуудад 14 хоног тутамд Улс, Нийслэл, дүүрэг орон нутаг, Төр захиргааны байгууллагаас өгөгдсөн үүрэг даалгавар, хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаг үеийн болон бусад асуудлаар мэдээ, мэдээлэл бэлтгэн тогтмол хэрэгжүүлж хэвшлээ.

Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд Хурлын Ажлын албаны 2, Намын бүлгийн Ажлын албаны 2 нийт 4 албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэж, Хурлын Ажлын албаны 10, Намын бүлгийн Ажлын албаны 3 нийт 13 албан хаагчид буцалтгүй тусламж олгон, Хурлын Ажлын албаны 4, Намын бүлгийн Ажлын албаны 2 нийт 6 албан хаагчийг сертификатын сургалтад хамруулж, Хурлын Ажлын албаны 4 албан хаагчийг гадаад арга хэмжээнд тус тус хамрууллаа.

Тайлант хугацаанд Хурлын Ажлын албан дахь Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан болон Улсын Их Хуралд суудалтай намын байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан албан хаагчдын судалгааг тус тус боловсруулан Нийслэлийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлжээ.

Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон Хурал, Тэргүүлэгчдээс дэвшүүлсэн зорилтын хүрээнд Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд Төлөвлөгөөнд тусгагдсан 13 ажил үйлчилгээнээс 13 ажил үйлчилгээг бүрэн хэрэгжүүлж, биелэлт 100 хувьтай байна. Мөн Хурлын Төлөөлөгч, Хурлын Ажлын албаны ажилтан, дүүрэг, хороодын Засаг дарга нийт 44 албан тушаалтны хөрөнгө орлогын 2017 оны мэдүүлгийг цахимаар хүлээн авч, бүртгэл, тайланг хуулийн хугацаанд хүргүүлж ажиллалаа.

Дүүргийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын 2018 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд 15 иргэнд нөхөн олговор олгохтой холбоотой асуудлаар мэдээлэл өгч, 1 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэн, холбогдох баримт материалд түшиглэн мэдээллийн санд бүртгэн, бүртгэл судалгааг жил тутамд шинэчлэн боловсруулж байна.

Шашин сүм хийдтэй харилцах чиглэлээр дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагуудын судалгааг жил тутам шинэчлэн, мэдээллийн санд бүртгэгдсэн 33 шашны байгууллагаас 13 нь буддын, 20 нь христийн шашны үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд шашны байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн 1, зөвшөөрлийн хугацааг сунгуулахыг хүссэн 7 байгууллагын өргөдөл, хүсэлтийг судлан үзэж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжиллаа.

ХОЁР. ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хурлын Төлөөлөгчдийн тойргийнхоо иргэд, сонгогчидтой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулсан Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлэг, “Өрхийн хөгжлийн төлөө хамтдаа” сургалт хэлэлцүүлэг, “Эрүүл иргэн-Өрхийн хөгжил” аян, уулзалт, хэлэлцүүлэг, Ахмад настны тухай хууль болон Алдар цолтон, ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулийн хэлэлцүүлэг, Олон нийтийн хяналтын зөвлөлийг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлэг нийт 5 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт, Үндсэн хуулийн өдрийн арга хэмжээ, Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ, УИХ-ын үйл ажиллагаатай танилцах арга хэмжээ нийт 4 удаагийн төвлөрсөн арга хэмжээ, БНТУ, БНХАУ, Япон улсад айлчлах 5 удаагийн гадаад арга хэмжээнд тус тус Хурлын Төлөөлөгчдийг хамруулсан байна.

Хурлын Төлөөлөгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сургалтын эрэлт хэрэгцээ, ажлын шаардлагыг нь харгалзан Хурлын Төлөөлөгчдийг зорилтод болон захиалгат 2 удаагийн сургалтад хамрууллаа. Үүнд:

Улсын Их Хурлын Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, Нэгдсэн Үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Төлөөлөгчийн манлайлал” сургалтыг “Монгол Улс дахь төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь төсөл”-тэй хамтран “Хувь хүний манлайлал”, “Улс төрийн манлайлал”, “Стратегийн манлайлал”, “Иргэдийн манлайлал” сэдвийн хүрээнд зохион байгууллаа.



Мөн Хурлын Төлөөлөгчдөд зориулсан “Өглөөний цай-Мэдээллийн цаг”-аар Монгол Улсын Хүндэт Дипломатч Ч.Батжаргалтай хамтран “Дипломат ёслол” сэдвээр сургалт, мэдээлэл хийсэн.

Хурлын Ажлын алба, Хурлын байгууллагын хамт олныг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх,

хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хүрээнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Хурлын Ажлын албаны ажилтан, албан хаагчдын дунд “Цэвэр агаар–Эрүүл мэнд-2018” цасны баярын арга хэмжээг зохион байгууллаа.



Мөн Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Улаанбаатар марафонд нэгдэцгээе” цом аялуулах аяны хүрээнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Хурлын Ажлын албаны ажилтан, албан хаагчдын дунд гар бөмбөг, дартсын төрөлт спортын тэмцээн, уралдааныг зохион байгуулснаас гадна Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Ажлын албаны ажилтнуудын дунд уламжлал болгон зохион байгуулагддаг “Хангарди-2018” спорт наадамд Хурлын Төлөөлөгч, Ажлын албаны ажилтан, албан хаагчдын бүрэлдэхүүнтэй баг, тамирчид спортын 5 төрөлд амжилттай оролцлоо.

Хурлын Төлөөлөгчдийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчилах хүрээнд тайлант хугацаанд “Масс Медиа” студитэй хамтран “Төлөөлөгчийн нэг өдөр” 20 минутын баримтат нэвтрүүлгийн зураг авалтад төлөвлөгөөний дагуу 7 Төлөөлөгчийг хамруулж, бэлтгэл ажлыг хангаж байна.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 07 дугаар тогтоол “Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дүрэм”-ийн дагуу 3 Төлөөлөгчийн эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлж, 3 Төлөөлөгчид буцалтгүй мөнгөн тусламж олгосон байна.

ГУРАВ. “ХУРЛЫН БАЙГУУЛЛАГААС ЗОХИОН БАЙГУУЛСАН ТӨВЛӨРСӨН АРГА ХЭМЖЭЭ”

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дэвшүүлсэн зорилт, Хурлын байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд иргэд, олон нийтэд чиглэсэн, бүтээлч, үр дүн бүхий төвлөрсөн арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг зохион байгууллаа.

Хурлын Тэргүүлэгчид, Ажлын албанаас зохион байгуулсан ажлаас дурдвал:

Монгол Улсад Ардчилсан Шинэ Үндсэн хууль батлагдсаны 26 жилийн ойн хүрээнд Үндсэн хуулиа сахин хүндэтгэх, хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх, үндсэн хуулийн үзэл баримтлалыг түгээн дэлгэрүүлэх, сурталчилах зорилгоор Чингэлтэй

дүүргийн харьяат, Үндсэн хууль батлалцсан, тухайн үеийн Ардын Их Хурлын Депутатуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг зохион байгууллаа.



Тус арга хэмжээнд АИХ-ын депутатаар ажиллаж байсан Чингэлтэй дүүргийн харьяат Г.Дэндэв, Н.Гаравсүрэн М.Шийрав нар оролцож, Хурлын Тэргүүлэгчид, Ажлын албаны удирдлагууд, ажилтан албан хаагчид болон дүүргийн Ерөнхий боловсролын 5,17, 23, 24, 49, 50, 61, 72 дугаар сургуулийн сурагчдын төлөөлөл оролцлоо.

Тайлант хугацаанд Хууль тогтоомж, Улс, Нийслэл, дүүрэг орон нутгийн бодлого, шийдвэрт иргэд, олон нийтийн оролцоог хангах, бодлого, шийдвэр, үйл ажиллагаагаа сурталчилан таниулах зорилтын хүрээнд дараах сургалт, хэлэлцүүлэгүүдийг зохион байгууллаа. Үүнд:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн чиглэлийн дагуу 1-19 дүгээр хорооны иргэдэд Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон иргэд, аж ахуй нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэхтэй холбоотой асуудлаар санал авах, тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэх зорилгоор дүүргийн Засаг даргын дэргэдэх Газрын албатай хамтарсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.



Хэлэлцүүлэгт дүүргийн 752 иргэн оролцож, 211 иргэнээс давхардсан тоогоор 237 санал, хүсэлт ирүүлсэнийг нэгтгэн Засаг даргын Тамгын газар болон дүүргийн Газрын албанд тус тус хүргүүлж ажиллалаа.

Шүүх хуралдаан, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохын зорилго, ач холбогдол, эдлэх эрх, хүлээх үүргийг тайлбарлан таниулах, шүүх байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, энэ талын эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор “Шүүхийн Иргэдийн Төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийг сурталчилан таниулах сургалтыг шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон, дүүргийн 173 иргэдэд Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй

дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газартай хамтран, хороодын иргэний танхимаар бүсчилсэн хэлбэрээр зохион байгууллаа.



Чингэлтэй дүүрэг 2018 оныг “Өрхийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран дүүргийн 18-38 насны залуусын төлөөлөл, ажил олгогч аж ахуй нэгж, байгуулагыг хамруулан “Өрхийн хөгжлийн төлөө хамтдаа” сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Сургалт, хэлэлцүүлгээр залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Төрөөс болон дүүрэг, орон нутгаас баримталж буй бодлого, үйл ажиллагааг танилцуулах, залуучуудыг ажлын байранд зуучлах, хөдөлмөрийн зах зээлд тавигдах ур чадварын шалгуурын талаар мэдээлэл өгч, залуучуудын хөдөлмөр эрхлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж, санал, хүсэлтийг хүлээн авлаа.



Мөн дүүргийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал, хөдөлмөр эрхлэлтийн талаар хийсэн 2016 оны тойм судалгаа, залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлс, шинээр байгуулагдаж байгаа хөдөлмөр эрхлэлтийн төвийн үйл ажиллагаа, “Дүүргийн хөгжил-Өрхийн хөгжлөөс” дэд хөтөлбөрийн төслийн танилцуулгыг тус тус хийж мэдээлэл өгөв.



Сургалт, хэлэлцүүлгийн үеэр “Нээлттэй ажлын байрны өдөрлөг” хөдөлмөр зуучлалын үйл ажиллагааг зохион байгуулсан ба уг хэлэлцүүлэгт дүүргийн харьяат 97 залуучууд, ажил олгогч аж ахуй нэгжийн төлөөллөөс Баясах Трейд ХХК, Баясах Интернэйшнл ХХК, Тайхар чулуу констракшн ХХК, Жүр-Үр ХХК тус тус оролцож, сургалт, хэлэлцүүлэгт оролцсон 31 залуучуудын хүсэлтийг хүлээн авч, сонирхсон ажлын байрны захиалгад бүртгэн, 1 хүнийг шууд ажлын байранд зуучилсан байна.



Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Дэлхийн Эрүүл мэндийн өдөр”-ийг тохиолдуулан “Эрүүл иргэн-Өрхийн хөгжил” сарын аяныг зарлан эрүүл мэндийн чиглэлийн сургалт, хэлэлцүүлэг, уулзалт ярилцлага, үзлэг оношлогоо, зөвлөгөө, мэдээлэл зэрэг олон хэлбэр бүхий арга хэмжээг дүүргийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, хороодын Засаг даргын Ажлын алба, Өрхийн эрүүл мэндийн төв, Улаанзагалмайн хороо, сайн санааны туслагч нартай хамтран зохион байгуулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид сонгогдсон хорооддоо хамтран ажиллалаа.



Тус аяны хүрээнд судалгаанд хамрагдсан Чингэлтэй дүүргийн 3-19 дүгээр хорооны 06 сартайгаас 5 настай жингийн алдагдалтай, өсөлт хоцролттой 115 хүүхдийг сонгон цагаан хорхой, рахит, цус багадалтыг тодорхойлж, тэдний эцэг, эх, асран хамгаалагчдад нь хүүхдийн нэмэгдэл хоолны 12 өдрийн сургалтыг Өрхийн эрүүл мэндийн төв, сайн санааны туслагч нартай хамтран зохион байгуулан, тухайн айл өрхүүдэд хоол хүнсний тусламжийг үзүүлэн, гарын авлагаар хангаж ажиллалаа.



Аяны хүрээнд дүүргийн болон өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран дүүргийн 7-19 дүгээр хорооны нийт 720 иргэдийг Эрүүл мэндийн тухай хууль, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого үйл ажиллагааг сурталчилан, таниулах, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх зорилго бүхий “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх” сургалтад хамруулсан ба дүүргийн ИТХ-ын Төлөөлөгчид иргэдтэйгээ хамтран оршин суугаа гудамж талбайн зохистой ашиглалт, цэвэр цэмцгэр эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх хүчин зүйлийн талаар зураглал гарган, санал солилцсон юм.



Мөн ахуйн бохирдлоос үүдэлтэй халдварт өвчинд өртөх өндөр эрсдэл бүхий 1-19 дүгээр хорооны 260 айл өрхөөс 3 шатны гэр үнэлгээний аргаар авсан судалгаанд үндэслэн 7-19 хорооны нийт 65 өрхөд эрүүл ахуйн стандарт, шаардлагад нийцсэн ундны усны сав, эрүүл ахуйн багцыг тараах үйл ажиллагааг хороодын иргэний танхимаар дамжуулан зохион байгууллаа.



“Эрүүл иргэн-Өрхийн хөгжил” сарын аяны хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааг ТВ9, ТВ25 дугаар суваг телевиз болон дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цахим сайтад байршуулан, сурталчилан ажиллалаа.

“Ахмад настны тухай хууль”-ийг сурталчилан таниулах, дүүрэг, орон нутгаас ахмад настны талаар баримтлах бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч үйл ажиллагаанд тусгах зорилгоор дүүргийн Ахмадын хороотой хамтран “Ахмад настны нийгмийн хамгаалал” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг 1-19 дүгээр хороодын ахмадуудын дунд батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу зохион байгууллаа. Тус сургалт, хэлэлцүүлгээр Ахмад настны тухай хууль тогтоомж, Ахмад настны хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төрөл, ахмад настны нийгмийн даатгал, тэтгэврийн зээл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаарх сургалт, мэдээллийг хийлээ.



Тус үйл ажиллагаанд дүүргийн ИТХ-ын 18 төлөөлөгч оролцож, ахмад настнуудад тулгамдаж буй асуудлаар санал солилцож, ахмадуудаас гарсан санал, хүсэлтийг хүлээж авлаа.

Сургалт, хэлэлцүүлэгт дүүргийн ахмадуудын төлөөлөл 1284 ахмад оролцож, давхардсан тоогоор 769 санал, хүсэлт гаргасаныг нэгтгэн дүүргээс сонгогдсон УИХ-ын гишүүн, дүүргийн Засаг дарга болон Ахмадын хороонд хүргүүллээ.

Мөн Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчилан таниулах зорилгоор “Гэр бүлийн боловсрол” сургалтыг дүүргийн Прокурорын газар, Улаанбаатар Их сургуулийн Хууль зүйн тэнхимтэй хамтран 1-19 дүгээр хороодын Иргэний танхимаар дамжуулан зохион байгууллаа. Сургалтын хүрээнд Гэр бүлийн тухай хууль, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага, гэрлэлт дуусгавар болох үндэслэл, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох журам, гэр бүлийн гишүүдийн хувийн болон хуваарьт өмч, хүүхэд үрчлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцаа, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль, гэр бүлийн орчинд үйлдэгдэх хүчирхийллийн хэв шинж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, илрүүлэх, таслан зогсоох, хүчирхийлэл үйлдэгдэх хэлбэр онцлогийн талаар иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өглөө.



Тус сургалтыг хороодын Иргэний танхимаар бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулсан ба дүүргийн нийт 1027 иргэн хамрагдлаа.

ДӨРӨВ. “ХОРООНЫ ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ, ИРГЭНИЙ ТАНХИМЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА”

Нутгийн өөрөө удирдах байгууллагыг анхан шатны нэгжид төлөвшүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнд:

Нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэх, хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Тэргүүлэгчдэд хууль тогтоомж, цаг үеийн мэдээ, мэдээлэл өгөх хороодын Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн зөвлөлдөх уулзалтыг 2 удаа зохион байгууллаа.

Мөн хорооны Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарыг чадавхжуулах хүрээнд шинээр батлагдсан Ахмад настны тухай хууль, Алдар цолтон, ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хууль, болон албан хэрэг хөтлөлтийн www.edoc.ub.gov.mn системийн талаар холбогдох мэдээ, мэдээллээр 2 удаагийн сургалт зохион байгууллаа.



Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд 13 хорооны Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарыг ӨМӨЗО-ны Ордос хотын Отог өмнөд хошууны “Дээд зэрэглэлийн үндэстний ажил мэргэжлийн сургууль”-ийн үйл ажиллагаатай танилцуулах, туршлага судлуулахаар тус хотод ажиллууллаа.



Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Олон нийтийн хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ын дагуу хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажлын чанар, гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавих үүрэг бүхий олон нийтийн хяналтын зөвлөлийг хороо бүрт байгуулж, хорооны Иргэдийн Нийтийн Хурлын даргаар ахлуулан, зөвлөлийн гишүүнээр сонгогдсон нийт 73 иргэнийг бүртгэлжүүллээ.

Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах хүрээнд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам, орон нутгийн хөгжлийн сангийн болон бусад холбогдох журмуудыг танилцуулга болон, дүүрэг, орон нутагт 2018 онд хийгдэх хөрөнгө

оруулалтын ажлын төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн талаарх танилцуулга бүхий сургалтыг зохион байгууллаа.



Хорооны Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Тэргүүлэгчдийг мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх хүрээнд хорооны Засаг даргын Ажлын алба, Өрхийн эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэсгийн 2017 онд зохион байгуулсан үйл ажиллагааны тайланг үнэлж, дүгнэх, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хийх ажлын талаар иргэдээс санал авах, эрэмбэлэх хуралдаан зохион байгуулах талаар зөвлөмж гарын авлага бэлтгэн хүргүүллээ.



Тайлант хугацаанд Иргэний танхимын үйл ажиллагааг иргэн бүрт жигд хүргэх зорилгоор Иргэний танхимын тогтмол үйл ажиллагааны хуваарь, зохион байгуулагдах үйл ажиллагааны төлөвлөгөөнд холбогдох албан тушаалтны саналыг тусган, тухайн хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан боловруулж, хорооны Засаг даргаар батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Мөн Иргэний танхимаар үйлчлүүлж буй иргэдийн тоон мэдээ, өргөдөл, гомдол, санал хүсэлт, цахим хаягт байршуулсан мэдээ, мэдээлэлд хийсэн тандалтын судалгааг сар тутамд гаргуулан авч, танхимаар дамжуулан зохион байгуулж буй үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийн, үр дүнг тооцон ажиллаж байна.

Хороодын Иргэний танхимаар дамжуулан иргэдээс 278 санал, хүсэлт ирүүлсэнээс цахимаар 112, утсаар 77, биечлэн 69, бичгээр 20 санал, хүсэлтийг хүлээн авч, 267 асуудлыг бүрэн шийдвэрлэж, 11 санал, хүсэлт шийдвэрлэх шатандаа байна.


Иргэдээс дуудлага, мэдээлэл хүлээн авах “Та дохь-би залгая” үүрэн холбооны утсанд Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлага, мэдээлэл-40, санал,

хүсэлтийн шинжтэй- 85 дуудлага ирүүлсэнийг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж, хариуг нь тухай бүр хүргүүлэн ажиллалаа.

Тайлангийн хугацаанд Иргэний танхимаар зохион байгуулсан үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчилах зорилгоор 1-19 дүгээр хорооны Иргэний танхимын нүүр хуудсанд 3561 удаа цагаан мэдээ бэлтгэн, давхардсан тоогоор 75321 хандалт авсан байна.

Иргэний танхимаар 2018 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 105 удаагийн сургалт, арга хэмжээ зохион байгуулсаныг агуулгаар нь ангилан үзвэл:

Эрүүл мэндийн чиглэлээр: Жирэмсэн үеийн эрүүл мэнд, В, С вирусын шинжилгээ, Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлье, Менингит өвчин гэж юу вэ?, 0-2 насны хүүхдийг хэрхэн зөв хооллох вэ?, Зөв өглөөний цай хоолны зохистой хэрэглээ, Эмнэлэгийн алдаанаас хэрхэн сэргийлэх вэ?, Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэхийн ач холбогдол, ариун цэврийн байгууламжаа хэрхэн сайжруулах бэ?, Төрөлтийн өмнөх үе, төрөх үеийн сэтгэл зүйн бэлтгэл, Гэрээр айлчлагч, Цэгэн бариа хийх аргачлал, Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлье, Өсвөр үеийн эрүүл мэнд, Хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжье, Архигүй орчин бидний ирээдүй, Жирэмсний явц дахь ургийн хөгжил, Оном сан эрүүл мэндийн сургалт, Сүрьеэ эдгэрдэг өвчин, Ажлын байран дахь дасгал хөдөлгөөн, орчны бохирдолоос үүдэлтэй Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, Эрүүл урт удаан наслахын төлөө хамтдаа, Байгууллагын эерэг зан үйл, Сонсголын түвшин тогтоох, Жирэмсний үед анхаарах аюултай шинж тэмдэгүүд, Усны бохирдол, хуванцар савны зөв хэрэглээ бидний эргэн тойронд, Дэлгэцийн донгоос хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэх бэ?, Ахмад настанд үзүүлэх асаргаа сувилгаа, Эрүүл шүд сургалт, Эрүүл зөв зохистой хооллолт, Гэр бүл төлөвлөлт, Эмэгтэйчүүдийн хавдрын өвчнийг эрт илрүүлэх, Ажлын байранд дахь хоол зүй болон ундны усны зөв хэрэглээ зэрэг сургалтуудыг тус тус зохион байгуулсан.



Хууль, эрх зүйн чиглэлээр: “Шүүхийн Иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Улсын яллагчийн мэтгэлцэх ур чадвар, Хуулиа мөрдье-21, Аз жаргалтай хотын индекс тооцох аргачлал, Гамшгийн эрсдэлийг тооцох үнэлгээ, Замын хөдөлгөөний аюулгүй байдал-Хүүхэд хамгаалал, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалтай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга,

Орон нутгийн удирдлага, Цахим гэмт хэргээс хүүхдээ хамгаалах нь, Гэр бүлийн боловсрол сургалт, Гэрч хохирогчийн аюулгүй байдлыг хангах, Хотын засаглалыг сайжруулах нь сургалт, Хамтарсан багийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх багийн гишүүдийн цагдаагийн ур чадварыг нэмэгдүүлэх нь сургалт, Дайчилгааны бэлэн байдлыг хангах, Асуудал ба шийдэл, Улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх сургалт мэдээлэл, Хууль эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө зэрэг сургалтуудыг тус тус зохион байгуулсан байна.



Хувь хүний хөгжлийн чиглэлээр: Англи хэлний анхан шатны мэдлэг олгох сургалт, Гэр бүлийн үнэ цэнэ, Гэр бүлийн баяр хөөр, Бизнесийн гараа, Соёлын дархлаа, Нийтийн бүжгийн сургалт, Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо, Төмс хүнсний ногооны үр ашиг, төлөвлөлт, хөрс боловсруулалт, хамгаалагдсан хөрсөнд тариалалт хийх аргачлал, Ажилтай, орлоготой залуус сургалт, Хүүхэд хүмүүжлийн эерэг арга, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Сэтгэл зүй бясалгалын сургалт, Хэрхэн хуримтлал үүсгэх бэ?, Өөрчлөлтийг өөрөөсөө эхэлье, гэрийн орчинд Гал түймрээс урьдчилан сэргийлье, Хороондоо сайхан амьдаръя, Амьдралын баталгаа сургалт, Хөдөлмөр өрхийн хөгжлийн үндэс, Гамшгийн эрдсэлийг бууруулах зорилгоор Бэлэн бай сургалт, Хуримтлал насан туршийн баталгаа болох нь, Аз жаргалтай залуу нас, Миний гэр бүл чадна хөгжөөнт тэмцээн, Төсөл бичих чадвар, Мод бут сөөг тарих сургалт, Жаргалтай ээжүүд, Хамтдаа энерги бэлэглэе, Хувь хүний давуу талаа хөгжүүлэх нь, Хүүхдийг эрсдэлээс хамгаалах аргууд гэх мэт сургалт, үйл ажиллагааг тус тус зохион байгуулсан байна.



Тайлант хугацаанд 1-19 дүгээр хороодын Иргэний танхимаар зохион байгуулагдсан сургалтад давхардсан тоогоор нийт 39712 иргэн хамрагдсан байна.

Уулзалт, хэлэлцүүлгийн чиглэлээр: Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт хэлэлцүүлэг, Сургуулийн өмнөх боловсролын 18 цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нарыг дундах Зөвлөн туслах багуудын ээлжилт хэлэлцүүлэг, 7 дугаар

хороонд байгуулагдах Сервис центр дэд бүтцийн төв байгуулах тухай хэлэлцүүлэг, Хороодын Иргэдийн Нийтийн хурал, Хорооны Ажлын алба, Цагдаагийн хэсэг, Өрхийн эрүүл мэндийн төвөөс 2017 онд зохион байгуулсан үйл ажиллагааны тайлангийн хурал, Сууц өмчлөгчдийн холбооны хурал, Бизнес инкубатор төвийн 2017 онд зохион байгуулсан үйл ажиллагааны тайлангийн хурал, Малтай өрхүүдийг зөвшөөрөгдсөн бүс нутагруу нүүлгэн шилжүүлэх тухай уулзалт, УИХ-ын гишүүн, НИТХ-ын Төлөөлөгчдийн иргэд сонгогчтой хийсэн уулзалт, Хороодын Иргэний танхимын дэргэдэх Залуучуудын клубын уулзалт, Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаа, Дархан бэрд өргөмжлөх өдөрлөг, Мөрдөстэй залуу нас өдөрлөг, Газар өмчлөх гэрчилгээ гардуулах өдөрлөг, Цахим орчин дахь хүүхэд хамгаалал уулзалт, Амжиргааны түвшин тогтоох уулзалт, Хорооны үйл ажиллагаатай танилцах оюутан сурагчдын уулзалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зохион байгуулах хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын талаарх иргэдээс ирүүлсэн саналыг эрэмбэлэх хэлэлцүүлэг, Ахмад настны нийгмийн хамгаалал хэлэлцүүлэг, Хүүхэд бүхэн инээж байг бэлэг гардуулах үйл ажиллагаа, Тариалан эрхлэх бүлгийн уулзалт, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсээс иргэдтэй хийсэн мэдээлэл, Төрийн байгуулагуудын нээлттэй хаалганы өдөрлөг зэрэг үйл ажиллагаа зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 22430 иргэн хамрагдсан байна.



Тогтмол үйл ажиллагааны чиглэлээр: Иргэний танхимын үйл ажиллагааг иргэд жигд хүргэх зорилготой тогтмол үйл ажиллагааны хуваарийн дагуу долоо хоног бүрийн тогтмол өдрүүдэд “Нийтийн бүжиг”, “Хийн дасгал”-ын цаг, “Архины эсрэг идэвхтэй амьдрал клуб”, “Сонин унших цаг”, “Бясалгал”-ын цаг, бүлгийн цаг, гудамж, байрны нийтийн эргүүлийн цаг, ахмадын цаг, эмэгтэйчүүдийн цаг, илтгэх урлаг, мэтгэлцээний цаг, гар урлалын дугуйлан, ширээний теннис, Бруно бясалгал, амьдрах урлаг, англи хэлний анхан болон ярианы англи хэлний сургалт, жирэмсэн эхчүүдийн дасгал хөдөлгөөн, Хамтдаа суралцъя, шатрын дугуйлан, Солонгос хэлний анхан шатны сургалт, үйл ажиллагаанд давхардсан тоогоор 4447 иргэн үйлчлүүлж, иргэдэд Төрийн үйлчилгээг жигд хүргэн ажиллаж байна.



Тайлангийн хугацаанд хороодын Иргэний танхимаар зохион байгуулсан үйл ажиллагаанд давхардсан тоогоор 66589 иргэн хамрагдсан байна.

ТАВ. “ХУРЛЫН ГАДААД, ДОТООД ХАРИЛЦАА, ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ”

Хурлын Тэргүүлэгчид түүний Ажлын албанаас Хурлын байгууллагын үйл ажиллагааны талаар хэвлэл, мэдээлэл, цахим хуудас, олон нийтийн сүлжээ, мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд бодитой, шуурхай, өргөн мэдээллийг тогтмол өгч ажиллаж байна. Тухайлбал:

Хурлын байгууллагаас баталсан бодлого, шийдвэр, зорилтоо иргэдэд шуурхай хүргэх, сурталчилах зорилгоор хэвлэл мэдээллийн ТВ-25, ТВ-9 телевиз, www.zaluu.com, www.infomongol сайт болон өдөр тутмын Өдрийн сонин, Өнөөдөр, Зууны мэдээ сонинтой тус тус хамтран ажиллах гэрээ байгуулан, үйл ажиллагаагаа сурталчилан, ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүүгийн нээлттэй ил, тод байдлыг ханган Хурал, Тэргүүлэгчдээс баталсан тогтоол шийдвэр, түүний хэрэгжилт, зохион байгуулсан үйл ажиллагаа болон цаг үеийн бусад **67** удаагийн мэдээ, мэдээллийг бэлтгэн www.chingelteicouncil.mn, www.chingeltei.ub.khural.mn цахим хуудас, олон нийтийн сүлжээ, мэдээллийн самбараар дамжуулан иргэд олон нийтэд сурталчилсан бөгөөд www.chingelteicouncil.mn цахим хуудсанд давхардсан тоогоор **197470** www.chingeltei.ub.khural.mn, цахим хуудсанд **208926** хэрэглэгч хандаж мэдээлэл авсан байна.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд найрсаг харилцаа бүхий БНХАУ-ын Манжуур хот, Эрээн хот, Хайлаар хот, БНСУ-ын Инчон хотын Сонгбук дүүрэг, БНТУ-ын Анкара хотын Синжан, Анаталия хотын Кемер дүүргүүдтэй байнгын харилцаатай ажиллаж, 20 удаа захидал, цахим шуудангаар харилцсан байна.

Мөн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг сурталчилах видео танилцуулгыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэлээ.

Тайлангийн хугацаанд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Бат-Эрдэнэ тэргүүтэй ажлын хэсэг БНХАУ-ын Эрээн хотод, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын бүрэлдэхүүнтэй хамтарсан ажлын хэсэг БНТУ-ын Анкара хотын Синжан дүүрэгт, Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ӨМӨЗО-ны Ордос хотын Отог Өмнөд хошуунд, Хурлын Тэргүүлэгч С.Амарбаясгалан тэргүүтэй ажлын хэсэг Япон Улсын Нийгата мужийн Госен хотод тус тус ажлын айлчлал хийлээ.

Айлчлалын үр дүнд БНТУ-ын Анкара хотын Синжан дүүрэгтэй хот тохижилт, гэр хорооллын дахин төлөвлөлт, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, нийгэм, соёлын чиглэлээр хамтран ажиллах, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ордос хотын Отог Өмнөд хошууны дээд зэрэглэлийн үндэстний ажил мэргэжлийн сургуультай богино хугацааны мэргэжил олгох хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэхээр тус тус

хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан, БНХАУ-ын Эрээн хоттой боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц, өрхийн үйлдвэрлэгчид, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр, Япон Улсын Нийгата мужийн Зүүн хойд Азийн эдийн засгийн хүрээлэнтэй хамтран 2018 оны 09 дүгээр сард Японы Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон Техник мэргэжлийн сургуулийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчилах үзэсгэлэн фестивалийг Чингэлтэй дүүрэгт зохион байгуулах, хамтран ажиллах, санамж бичигт үзэглэх зэрэг яриа хэлэлцээрийг хийлээ.

Тайлант хугацаанд Тайвань Улсын Нанхуа их сургуулийн дэд захирал, профессор Ван И Ү зочид төлөөлөгчдийг Чингэлтэй дүүрэгт хүлээн авч уулзан, дүүргийн ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийг тус Улсын Нанхуа их сургуульд тэтгэлэгтэй суралцуулах талаар харилцан санал солилцлоо.

Дотоод томилолт, арга хэмжээний хүрээнд Увс аймгийн Ховд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга н.Давааням тэргүүтэй зочид Төлөөлөгчид, Ховд аймгийн Дуут сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Л.Нарангэрэл тэргүүтэй зочид Төлөөлөгчид, Завхан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ц.Балхярваа тэргүүтэй зочид Төлөөлөгчид, Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Ганбаатар тэргүүтэй зочид Төлөөлөгчдийг тус тус Чингэлтэй дүүрэгт хүлээн авч, харилцан туршлага солилцлоо.



Мөн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанаас санаачилан Нийслэл, дүүргүүдийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлага солилцох, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, шинэ санаа санаачилгыг дэмжих зорилгоор “Хамтдаа суралцъя-хамтдаа хөгжье” туршлага солилцох уулзалтыг зохион байгууллаа.



Уулзалтад Нийслэлийн 9 дүүргийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга бөгөөд, Хурлын Ажлын албаны дарга нар оролцож дүүргийн ИТХ-ын хороод, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хороодын Иргэдийн

нийтийн Хурлын дарга нарын үйл ажиллагаатай танилцан, хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар харилцах санал солилцов.

ЗУРГАА. “ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА”

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг хангуулах, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн цогц бодлогыг хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд бүх нийтийн оролцоог бий болгох, хамтран ажиллах замаар камерийн хяналттай, гэмт хэрэг, зөрчилгүй хороо, дүүрэг болгох зорилт дэвшүүлэн ажиллалаа.

Дээрх зорилтын хүрээнд дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2018 онд хэрэгжүүлэх 5 бүлэг, 44 зүйл бүхий төлөвлөгөөний төсөл боловсруулан зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, тайлант хугацаанд төлөвлөсөн 23 ажлаас 20 ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, 3 ажил удирдлагын заалтаар хойшилж, биелэлт 86,9 хувьтай байна.

Тайлант хугацаанд дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 6 удаа хуралдаж, 28 асуудлыг хэлэлцэн, 27 тогтоолыг батлан хэрэгжилтийг ханган ажилласнаас гадна байгууллага, иргэдээс 12 бичиг тоотыг хүлээн авч, 29 бичиг тоотыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах, иргэдийн эрүүл, аюулгүй амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн цогц бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд 8 зорилт бүхий “Иргэдийн оролцоотой хяналттай орчин” дүүргийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Тус хөтөлбөрийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө хамтдаа” Анхдугаар зөвлөгөөнийг 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдөр холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.



Зөвлөгөөнд дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчид, ГХУСАЗСЗ-ийн гишүүд, дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын дарга нар, 1-19 дүгээр хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Засаг дарга нар, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн удирдлагууд, Аж ахуйн нэгж, байгууллагууд, Нийслэлийн төр

захиргааны байгууллагуудын төлөөллүүд оролцсон бөгөөд зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг арилгахад хамтран ажиллах зорилгоор зарим аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан, зөвлөгөөнд оролцогчдын санал, хүсэлтийг сонсон цаашдын үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.

Дээрх зөвлөгөөний үр дүнг хэлэлцэн дүүргийн нутаг дэвсгэрт зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг бууруулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөлийг салбар зөвлөлийн дэргэд байгууллаа.

Мөн дүүргийн Засаг даргын Тамгын газар, Замын цагдаагийн хэлтэстэй хамтран “Замын хөдөлгөөний цагаан толгой” уралдааныг Төрийн өмчийн 23, хувийн хэвшлийн 1 нийт 24 цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулсанаас гадна “Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлье” сэдэвт сургалтыг дүүргийн Ерөнхий боловсролын төрийн өмчийн 12 сургуулийн сурагчид, тэдгээрийн эцэг эхчүүдэд үе шаттайгаар зохион байгуулж байна.



Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдлэг, мэргэжлийн чиг баримжаа олгох үүрэг бүхий “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм”-ийг байгуулж, тэдгээрийн ажиллах журмыг Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Ерөнхий боловсролын сургуулиудын Өсвөрийн сэргийлэгч сайн дурын бүлгэмийн гишүүдийн Анхдугаар чуулга уулзалтыг зохион байгуулан, бүлгэмийн гишүүдэд ажиллах журмыг танилцуулах, гишүүдэд энгэрийн тэмдэг, дүрэмт хувцас гардуулах үйл ажиллагааг зохион байгууллаа.



“Хүүхдийг зодож, шийтгэхгүй байх” Олон Улсын өдрийг тохиолдуулан Чингэлтэй дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, ДЗМОУБ-ын “Хайлааст”, “Чингэлтэй” ОНХХ-тэй хамтран өдөрлөг зохион байгуулж, “Хүүхэд хамгаалал ба бидний оролцоо” сэдэвт илтгэлийн тэмцээнд шалгарсан сурагчид, нийгмийн ажилтнуудыг шагнаж урамшууллаа.



Тайлангийн хугацаанд Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай нийтийн байруудад Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөт бус шалгалтыг холбогдох хэлтэс албадтай хамтран зохион байгуулж, нийт 155 объектоос 124 объектод хяналт шалгалт хийж 620 зөрчил илрүүлж, 178 зөрчил буюу 28.7 хувийг газар дээр нь арилгуулж, бусад зөрчил дутагдлыг арилгуулахаар байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 84, Мэдэгдэл 21-ийг бичиж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан, иргэдэд хүргүүллээ.

Мөн 1-19 хороодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах багийн гишүүдийн дунд үйл ажиллагааг нь дэмжих, ажлын уялдаа холбоог сайжруулах, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилго бүхий үзүүлэх сургалтыг 2017 онд үйл ажиллагаагаараа тэргүүн байрт шалгарсан 3 дугаар хороонд зохион байгууллаа. Тус хорооны баг өөрийн сайн туршлагаасаа хуваалцан, харилцан туршлага солилцлоо.



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх баг, гудамж, байрны нийтийн эргүүлүүд дүүргийн хэмжээнд ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд үйл ажиллагааг нь дэмжих, эрчимжүүлэх зорилгоор дараах аян, уралдааныг зарллаа. Үүнд:

➤ Хороодын гудамж, байрны нийтийн эргүүлүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, “Хулгайлах” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн гаралтыг бууруулах зорилго бүхий “Миний гудамж-Гэмт хэрэг зөрчилгүй гудамж” 3 сарын аяныг дүүргийн 1-19 дүгээр хороодын нийтийн эргүүлүүдийн дунд;

➤ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах зорилго бүхий “Гэмт хэрэг зөрчилгүй байгууллага, хамт олон” 8 сарын хугацаат аяныг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй томоохон худалдаа үйлчилгээний төвүүд, захуудын дунд;

➤ Хороодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах багуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх, дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах, шинэлэг санал санаачилгуудыг дэмжих зорилго бүхий хороодын урьдчилан сэргийлэх багуудын дунд төслийн уралдааныг тус тус зарлан, 8, 9, 11, 13, 14, 16 дугаар хороодын 7 төслийг шалгаруулан шаардагдах төсвийг санхүүжүүллээ.



Тайлангийн хугацаанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах үйл ажиллагаанд туслах чиг үүрэг бүхий нийт 647 иргэн гудамж, байрны нийтийн эргүүлээр, 19 иргэн хэв журмын урамшилт эргүүлээр тус тус ажиллаж байна.

Хороодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх багууд нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулсан ажлын тайлан мэдээ, үр дүнг сар тутамд дүүргийн ГХУСА33-д тайлагнан, ажиллаж байна.